



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/295

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 38 дугаар зүйлийн 38.1, 38.2, 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Баярмагнай овогтой Түмэн-Өлзий (РЭ88121431)-ийн хүсэлтийн дагуу аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/293 дугаар захирамжаар Мөрөн сум 8 дугаар баг Ширэндэв-1, 115а тоотод байршилтай 1862м<sup>2</sup> үйлчилгээтэй орон сууцны зориулалттай газрыг хуулийн этгээд “Идэр нумт” ХХК (4125827)-д 26 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн өдрийн А/293 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

3. Захирамжаар газар эзэмшигч хуулийн этгээд “Идэр нумт” ХХК (4125827)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН